



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 752

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2019 он, 2020 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалт, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагчийн дүгнэлтээр нийт 5,485.4 (таван тэрбум дөрвөн зуун наян таван сая дөрвөн зуун мянга) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөсүгэй:

2.1. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд хяналт тавьж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлж ажилласан удирдах болон бусад эрх бүхий албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох;

2.2. Хууль хяналтын байгууллагын гаргасан шийдвэрийг үндэслэн гүйцэтгэх захирлын эрх мэдлээ хэтрүүлэн зарцуулсан, хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээний дагуу өмгөөллийн хөлсөнд төлсөн 84,000.0 сая (наян дөрвөн сая) төгрөгийг компанийн холбогдох албан тушаалтнуудаар нөхөн төлүүлэх эсэхийг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах;

3. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Л.Эрхбаатарт дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

3.2. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэлийг сайжруулах, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал, ажил үйлчилгээг санхүүжүүлэхгүй байх;

3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу үндсэн хөрөнгийг олж авахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч ажиллах;

3.4. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар тогтоолын 2.2-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байх гэж заасныг мөрдөн ажиллах;

132007085

3.5.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах;

3.6.“Хуучин сэлбэг материал хүлээн авах, худалдах, дахин ашиглах журам”-ын хуучин сэлбэг худалдах үнэ үнэлгээг шинэчлэн тогтоох, байгууллагын Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажлын үр нөлөөг дээшлүүлэх;

3.7.Байгууллагын санхүүгийн авлагаар бүртгэлтэй, компанийн ажилтан Э.Энхмөнхөд зээлээр худалдсан, орон сууцны 53.7 сая төгрөгийн авлагыг 2022 оны 2 дугаар улиралд багтаан бүрэн барагдуулах, цаашид төрийн өмчийн хөрөнгийг бусдад үнэ төлбөргүй ашиглуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг баримтлан ажиллах;

3.8.Компанийн үндсэн хөрөнгийн барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй, үндсэн үйл ажиллагаанд ашиглагддаггүй орон сууцны барилгуудыг хувьчлах, худалдах асуудлыг судлан шийдвэрлэх, үнэ төлбөргүй ашиглуулж байгаа барилга, орон сууцыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу ашиглуулах, хөрөнгийн үр ашгийг сайжруулах;

3.9.“Соёмбо констракшн” ХХК-д компанийн орлогын дансыг барьцаалан батлан даалт гаргасан эсэх асуудлаар холбогдох харилцагч банкнаас албан ёсны лавлагаа, тайлбар гаргаж ирүүлэх;

3.10.Төрийн өөрийн өмчийн байр талбай, цайны газрын сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй зохион байгуулж, төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээнд заасан барьцаа төлбөр, хөрөнгө оруулалт, их болон урсгал засвартай холбоотой заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах;

3.11.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх, давтан гаргасан ажилтан, албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу тухай бүр хариуцлага тооцож байх.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
22 дугаар тогтоолын хавсралт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал түүнийг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /сая.төг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Батлагдсан төлөвлөгөөнөөс зардлыг хэтрүүлсэн, үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй үргүй зардал санхүүжүүлсэн.	210.2	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх хэсгийг мөрдөн ажиллах.
2	Албан тушаалын давуу байдлаа ашиглан худалдан авалт, зардлын төлөвлөгөөнд тусгагдаагүй зардлыг санхүүжүүлсэн.	84.0	Хууль хяналтын байгууллагын гаргасан шийдвэрийг үндэслэн төлбөрийг нөхөн төлүүлэх арга хэмжээ авах.
3	2019 он, 2020 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган биелүүлээгүй.	-	Компанийн тухай хуулийн 76.1.9, Гүйцэтгэх захиралтай байгуулсан Конрактын 3.2 дах заалтыг хэрэгжүүлэн ажиллах.
4	2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө бэлтгэхдээ эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй.	322.7	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах шилжүүлэх журам”-ыг мөрдөн ажиллах.
5	Соёмбо констракшн ХХК-д хөрөнгийн баталгаа гаргасан талаар	2,600.0	“Дулааны 3 дугаар цахилгаан станц” ТӨХК нь “Соёмбо констракшн” ХХК-ийн зээлийн үйл ажиллагаанд батлан даалт гаргасан эсэх асуудлаар холбогдох харилцагч банкнаас /Хаан/ тодорхойлолт гаргуулан ирүүлэх.
6	Төрийн өөрийн өмчийн ашиглалттай холбоотой зөрчлийн талаар	-	Төрийн өөрийн өмчийн байр талбай, цайны газрын сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй зохион байгуулах, тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж батлуулах, түрээсийн гэрээнд заасан барьцаа төлбөр, хөрөнгө оруулалт, их болон урсгал засвартай холбоотой заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах.
7	Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээнд заасан барьцаа төлбөрийг Төрийн сангийн дансанд байршуулах.	15.9	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн журмыг мөрдөн ажиллах.

8	Худалдан авах ажиллагааны тухай хуулийн 34.1, 8.5 дахь заалтуудыг зөрчсөн.	1,782.1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмуудын хэрэгжилтийг ханган ажиллах.
9	Гэрээний хэрэгжилт, бараа материалын нийлүүлэлттэй холбоотой зөрчлийн талаар	470.1	Гэрээний үүргийн хэрэгжилтийг ханган ажиллах, гэрээнд заасан алдангийг тооцох, дараагийн тендер шалгаруулалтад тухайн үр дүнгийн үзүүлэлтийг харгалзан үзэх.
	Нийт дүн:	5,485.4	(Таван тэрбум дөрвөн зуун наян таван сая дөрвөн зуун мянга)